

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧИН БАЙГАЛЫН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА


.....Ц.УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ ХЭРГЭЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН.

“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....*М.Тилеуберди* М.ТИЛЕУБЕРДИ

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭРЧИМБАЯН-ӨЛГИЙ” ХК-ИЙН ДУЛААНЫ СТАНЦЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Хүлээн авч хянасан:

БОАЖГ-ын ХБОБНУГ-ын мэргэжилтэн:П.Шинэцэцэг

Боловсруулсан:

“Эрчимбаян Өлгий”ХК-ийн Химийн инженер:.....*М.Хажы* М.Хажы

Өлгий 2023 он

1 ДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр: Дулааны станц

Төслийн ангилал: “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хавсралтын дагуу “Дэд бүтэц” ангилалд хамаарна.

Талбайн хэмжээ: 2.43 га (24357 м²) Төсөл хэрэгжүүлэгч: “Эрчимбаян Өлгий” ХК
Улсын бүртгэлийн дугаар: 0210001004 Регистрийн дугаар: 2003821

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Монгол улс, Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 4-р баг
Утас: 99422512

1.1.1 Төслийн зорилго, зорилт

Тус станц нь дулааны эрчим хүч үйлдвэрлэж, Өлгий сумын төвийн хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр тасралтгүй хангах зорилготой бөгөөд энэ зорилгодоо хүрэхийн тулд дулааны шугам сүлжээ, дулааны станцын байнгын бэлэн байдлыг хангах, өргөтгөх, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх зэрэг зорилт тавин ажилладаг.

“Эрчимбаян Өлгий” ХК-ийн дулааны станц нь стратегийн онцгой ач холбогдолтой объект бөгөөд аймгийн хэмжээний дулааны эрчим хүчний нэгдсэн бодлогыг барьж хэрэгжүүлдэг учир байнгын бэлэн байдлыг хангаж, ямар нэгэн аваар, осолгүй ажиллах нь хэрэглэгчдийг найдвартай дулааны эрчим хүчээр хангах чухал ач холбогдолтой юм.

1.1.2 Компаний товч танилцуулга

Тус компанийн анхны тулгын чулуу 1952 онд тавигдсан. Аймгийн хэмжээнд 1952- 1965 онд 54 квт/цагийн хүчин чадалтай дизель станц, 1965 оноос 2500 квт хүчин чадалтай ДЭС-60 дизель станц тус тус ажиллаж, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан станцын захиргаа байгуулагджээ. байв. 1982 онд 4512 квт хүчин чадалтай дизелийн цахилгаан станц ашиглалтад орж, Эрчим хүчний нэгдсэн үйлдвэр байгуулагдсан бөгөөд тус үйлдвэр 1999 онд төрийн өмчийн оролцоотой “Эрчим” ХК болж, улмаар 2006 онд нээлттэй дуудлага худалдаагаар бүрэн хувьчлагдсан.

“Эрчимбаян Өлгий” ХК-ийн дулааны станц нь Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвийн 42 төжсөвт байгууллага, 51 аж ахуйн нэгж, 522 айл өрхийг дулааны эрчим хүчээр хангадаг бөгөөд нийт 700 орчим хэрэглэгчидтэй. Бүтэц, зохион байгуулалтын хувьд захиргаа, санхүүгийн алба, ашиглалт, дулааны шугам сүлжээ, цахилгаан, авто засвар, түлш дамжуулах, зуух засварын хэсэг зэрэг нэгжтэй, мөн Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт “Хотгор 1 дүгээр давхарга” нүүрсний уурхай, Улаанхус, Дэлүүн сумдын нэгдсэн халаалтын салбартай. Нийт 150 орчим ажиллагсадтай.

Тус станц нь ОХУ-д үйлдвэрлэсэн тус бүрт 16 мВт хүчин чадалтай КЕ 25-14 маркийн 3 ширхэг зуухтай, БНХАУ-д үйлдвэрлэсэн ДЗЛ-10 мВт-ийн хүчин чадалтай 1 зуухтай, бүгд 58 мВт хүчин чадалтай зуухтай.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дахь “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн Дулааны станцын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2019 Байгаль орчны судалгаа, үнэлгээний зөвлөх “Байгаль-Экологи” ХХК-д боловсруулав. Мөн Газрын төлөв байдал хянан батлгааг хийлгэсэн байна. 2020 онд Дулааны станцын Байгаль орчны Аудитын тайланг Увс аймгийн эрх бүхий “МӨСТИЙН РАШААН” ХХК-аар хийлгэж тэрний дагуу төлөвлөгөө гаргаж ажиллав. Мөн тус компаниар 2022 онд Аудитын тайланг дахин гаргуулж ажиллаж байна. Компанийн жилийн хэрэгцээт нүүрсийг Өлгий сумаас 140 км-ийн зайд орших Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг дахь “Хотгор 1 дүгээр давхарга” нүүрсний уурхайгаас шууд бэлтгэн нийлүүлдэг.

Уурхайн батлагдсан нөөц нь 20.0 сая тонн, жилд дунджаар 25.0-30.0 мян.тн нүүрс авч хэрэглэдэг. Тус уурхайн нүүрсний дулаан гаргах илчлэг нь 4100 ккал/цаг бөгөөд дулааны станц нь аймгийн нийт нүүрсний хэрэгцээний 30%-ийг хэрэглэдэг. 2014 оны байдлаар 19253 у/м дулааны хос шугам, үүнээс гол магистраль шугам нь 4928 у/м шугамаар дамжуулан 37000 м2 талбай бүхий 751 айл өрх, 316.6 мян.м 3 эзлэхүүнтэй 151 аж ахуйн нэгж, байгууллагыг дулаанаар хангаж байна.

Хэрэглэгчид шууд схемээр дулаанаар хангагддаг бөгөөд захиргаа, эмнэлэг, 36 айлын орон сууц, 40 айлын орон сууц зэрэг барилгуудад хэрэгцээний халуун усны хурдны ус халаагч байдаг. Өнөөдрийн байдлаар Өлгий хотын дулааны нийт ачаалал 20 орчим Гкал/цаг байгаа нь 58 мВт хүчин чадалтай Дулааны станцын хувьд хангалттай нөөцтэй байгаа нь харагдаж байна.

Мөн Өлгий хотод 10 бие даасан нам даралтын тогоотой байгууллага байдаг. Ойрын жилүүдэд Өлгий хотод 648 айлын орон сууцны “Кутты-Мекен” хороолол болон 900 айлын орон сууцны хорооллууд төлөвлөгдөж, инженерийн шугам сүлжээний ажлын зургууд хийгдэж дууссан байгаагаас гадна 373 айлын орон сууцны 8-10 барилга барихаар хувь хүн, компаниуд техникийн нөхцлөө аваад байгаа юм байна. Иймээс цаашид дулаагүй эрэлт хэрэгцээ улам нэмэгдэх төлөвтэй байна.

Улаанхус, Дэлүүн сумдын нэгдсэн халаалтыг Засгийн газраас хэрэгжүүлсэн “Сумдын төвийн нэгдсэн халаалт” төсөл арга хэмжээний хүрээнд 2014 онд төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж ашиглалтад оруулсан.

Эдгээр сумдын Засаг даргын Тамгын газар, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг бүх төсөвт байгууллагууд нэгдсэн халаалтад холбогдсон бөгөөд

цаашид өргөтгөж хувийн орон сууц, үйлчилгээний газруудыг нэгдсэн халаалтад холбох боломжтой.

Дулааны дэд станцад 2014 онд 2, 2015 онд 1 ялтсан бойлерийг шинээр суурилуулж хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Тус компани нь 2009 оны ажлын үр дүнгээр Эрчим хүчний системд 2-р байранд шалгарсан ба 2015 онд мөн Гааль, татварын ерөнхий газраас “Шилдэг татвар төлөгч” байгууллагаар шалгарч цом, өргөмжлөлөөр шагнуулсан байна. 2022онд К4-р зуухыг усан тавьсан зуух болгож өөрчилсөн.

1.1.3 Ажиллах хүч

Компани нийтдээ 130 ажиллагсадтай бөгөөд түүний 10 нь захиргаа санхүүгийн ажилтнууд, 22 инженер техникийн ажилтнууд, 82 нь үйлдвэрийн үндсэн ажиллагсад, 8 нь үндсэн бус үйлдвэрийн ажиллагсад, 8 нь тус компаний эзэмшлийн Нүүрст хотгор 1, 2 дугаар давхаргын нүүрсний ил уурхайн ажиллагсад байна. Нийт ажиллагсдын 40 хувийг 35 хүртэлх насны залуучууд, 11 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Боловсролын хувьд магистр 5, бакалавр 27, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 23, мэргэжлийн анхан шатны боловсролтой 20, бүрэн дунд боловсролтой 34, бүрэн бус дунд боловсролтой 21 байна.

Гадаад, дотоодын их, дээд сургууль, Баян-Өлгий аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг сургалтын байгууллагуудыг дулааны эрчим хүчний чиглэлээр төгссөн инженер, дунд боловсролтой мэргэжлийн ажилчдыг ажлын шаардлагыг харгалзан сонгон авч ажиллуулдаг.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дахь “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн Дулааны станцын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2019 Байгаль орчны судалгаа, үнэлгээний зөвлөх “Байгаль-Экологи” ХХК-д боловсруулсан.

1.2 Төслийн байршил

“Эрчимбаян-Өлгий” ХК-ийн дулаан үйлдвэрлэх, түгээх станц нь Алтайн уулархаг их мужийн Монгол Алтайн нурууны хэсэгт хамаарагдах Бөхөн уулын ар бэлд, Өлгий хотын төв хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос баруун тийш 1700 км зайд байрлана. Уул нурууд нь далайн түвшнээс дээш 1890-1910 м хүртэл үнэмлэхүй өндөртэй, хажуу нь эгц хад чулуутайгаас гадна гүн хавцал нарийн хөндийгөөр ихээхэн хэрчигдсэний зэрэгцээ тектоникийн гаралтай газар оршино.

Дулааны станц нь Өлгий сумын 4-р багийн нутаг дэвсгэрт, хуучин хүнсний үйлдвэрийн зүүн урьд талд гэр хорооллын бүсэд байршдаг. Тус станцын 2.4 га талбай нь байрзүйн зургийн L-45-120 хавтгайд орших ба талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолыг дараах хүснэгтэд үзүүлэв.

2 ДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ

2.1.1 Зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Тиймээс Өлгий дулааны станцын үйл ажиллагааны явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцлөө бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхийн хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
2. БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

2.1.2 Хамрах хүрээ

Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9-р зүйлийн 8-р заалт: “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь доорх бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Тус дулааны станц нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, байгалийн баялгийг зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчны менежментийн дараах бодлогыг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

- Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөх;
- Байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэлийг байнга сайжруулах;
- Байгаль орчинд халгүй, үйл ажиллагааны үр ашгийг тогтмол дээшлүүлэх шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэхийг эрмэлзэх.

Менежментийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Байгаль орчны менежментийн тогтолцоог боловсруулж, хэрэгжүүлэх;
- Дулааны станцын удирдлагууд болон ажилтнууд, оршин суугч иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ажил хэрэгч харилцааг хөгжүүлэх;
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр хамтран ажиллах;
- Байгаль орчинд аюулгүй үйлдвэрлэлийг хангахын тулд нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийг тооцсоны үндсэн дээр үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болох сөрөг үр дагаврыг аль болох доод түвшинд тогтоон барих;
- Байгаль орчны хяналт-шинжилгээний үр дүнг байгаль орчны хамгааллын бодлогод ашиглах, хяналт тавьж ажиллах;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хөрөнгө нөөцөөр хангах;
- Менежментийн бодлогыг олон нийтийн хүртээл болгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх болно.

2.2 БОМТ-ний товч танилцуулга

2.2.1 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарчим

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төсөл хэрэгжүүлэх менежментийн бодлогоор хэрэгжүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаагаа журамлах үүднээс байгууллагын дотоод журам, дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол улсад мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцсэн байхаар боловсруулан холбогдох нэгж, хэлтэс, цех тасгуудад таниулан ажиллагсдыг сургаж, дадлагажуулна. Энэ бүхэнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа, түүнтэй холбоотойгоор үүсэх сөрөг нөлөөллийг харгалзан хэрэгжүүлэх боломжтой хувилбаруудыг сонгох;
- Төсөл хэрэгжих нутгийн экологийн орчныг судалж, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалж хамгаалахад болон хүн амын эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж, бий болгоход БОМТ-г чиглүүлэх;
- Байгаль орчны хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж зэргийг мөрдөж ажиллах;
- Хот, суурин газрын бүсэд үйл ажиллагаа явуулж, тухайн бүс нутгийн иргэд, оршин Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дахь “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн Дулааны станцын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2019 он Байгаль орчны судалгаа, үнэлгээний зөвлөх “Байгаль-Экологи” ХХК-д боловсруулсан.

2.2.2 БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний зардал

2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөөг хэрэгжүүлэхэд нийт 14.497.000 мянган төгрөг, үүнээс байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд 12.397.000 мянган төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2.100.000 мянган төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 6.1. БОМТ-г хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах зардал

1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ 8.108 007

1.2 Ногоон бүс зохион байгуулах 2 039 004

1.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

1.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн төлбөр олгох

1.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

1.6 Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө 500 000

1.7 Хог хаягдлын менежментийг зохион байгуулах 1.500.000

1.8 Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ 2 000 000

1.9 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх 350. 000

2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр хийгдэх ажил

2.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 2.100.000₮

Нийт зардал 16.550.000₮

2.2.3 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт

Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчин, оршин суугчдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч, хамтран гүйцэтгэгч байгууллага, орон нутгийн удирдлага болон иргэдийн хамтын ажиллагаа шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь: БОННУ-ний шаардлагад тавигдсан үр дүнг гарахуйц нөхцөлөөр станцын бүтэцийг зохион байгуулж, холбогдох нэгж, хэлтсийн ажил үүргийг хуваарилана, дулааны станцын үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн зохион байгуулалтыг хийж, хамтрагч болон гүйцэтгэгч компаниудад холбогдох шаардлагыг тавьж ажиллаж байна.

Мөн дулааны станцын орлогч дарга, ХАБЭА-н инженер сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөлтийн голлох ажлуудыг хариуцан гүйцэтгэх бөгөөд захиргаа-удирдлагын хэлтэс нь шийдвэр гаргалт, шаардлагатай зарим арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангахад дэмжин туслах үүрэгтэйгээр оролцоно.

Орон нутгийн зөвлөл. БОННУ-нд заасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, БОМТ-нд заасан хяналтын ажилд оролцож, оршин суугчдад мэдээлэл хүргэх, станцын үйл ажиллагаа болон хяналт-шинжилгээний үр дүнг орон нутгийн оршин суугчдад таниулах зэргээр төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн удирдлагатай хамтран ажиллана.

Орон нутгийн иргэд, олон нийт. Орон нутгийн иргэд, олон нийт тус компанийн хэрэгжүүлэх байгаль хамгаалал, ногоон бүс тохижуулах, шаардлагатай тохиолдолд станцын нөлөөллийн бүсээс нүүлгэн шилжүүлэх зэрэг ажилд хамтран ажиллахаар зөвлөл зохион байгуулж, түүнд оролцож болно.

Тухайлбал:

- Ажилд орохыг хүссэн иргэд тусгай сургалтад хамрагдах, хөдөлмөрийн сахилга бат эзэмших, өөрийгөө боловсруулах;
- Станцын орчимд нутагшилтай, байнгын суурьшилтай айл өрхүүдээс иргэд, орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцох;
- Сумын болон аймгийн захиргааны ажилтнуудаас байгаль орчин, газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мөн зөвлөлд оролцуулах.
- Хамтран ажилласан тохиолдолд ажилласан хугацаа, ажилд тохирсон хөдөлмөрийн хөлсийг төсөл хэрэгжүүлэгч олгож болох бөгөөд хэрвээ байнгын зөвлөл зохион байгуулбал түүнийг журамлах хэрэгтэй болно.

2.3 Байгаль хамгаалах төлөвлөгөө

2.3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө:

БОННУ-ний тайланд төслийн цар хүрээнд бий болох сөрөг нөлөөллийн эрчим нь багаас их түвшинд хэлбэлзэх бөгөөд сүйрлийн хэмжээнд хүрэх ноцтой сөрөг нөлөө үгүй гэж тодорхойлсон. Энэ нь төсөл хэрэгжүүлэх нутгийн байгаль, газарзүйн байршил, байгалийн нөөцийн нөхөн сэргэх чадавхтай холбоотой байх тул сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах боломжтой байна.

2. 3.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Хугацаа ба давтамж	Нийт зардал, мян.төг	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР					
Утаа шүүгч системүүдийн хэвийн ажиллагааг хангах ➢ К-2,3-р зуухны батерийн циклонт их засвар хийх	Хүрээлэн буй орчны агаарын чанарт станцын яндангаас хаягдах агаар бохирдуулагчдын үзүүлэх нөлөө багасгах	2023онд	Үйл ажиллагааны зардал тусна.	Ашиглалтын инженер Засварын хэсэг	Байгаль хамгаалах тухай хууль, “Агаарын тухай”, “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль, MNS 4990:2010 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага. MNS 0017-2-3-16:1998 (хүн амын суурьшсан хэсгүүдэд) MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
Нүүрс тээвэрлэлт болон үнс зайлуулах системийг хамгийн зохимжтойгоор шийдвэрлэх	Станцын талбайгаас хаягдал үнс, нүүрсний тоос салхиар дэгдэж орчны агаарын чанарт үзүүлэх нөлөө багасна ➢ Мэргэжилийн байгууллагаар шинжилгээ хийлгэнэ. ➢ Амгийн БОАЖГ-аас өгсөн албан шаадлагын дагуу	2023 онд	Үйл ажиллагааны зардал тусна.	Ашиглалтын инженер ХАБЭА-ийн инженер	
Зуухнаас гарсан үнс болон утаанаас дээж авах цэг гаргах		2023 онд	400.0	Ашиглалтын инженер, Засварын инженер	
Түлш дамжуулахын салхилуураас гарах бургиаг арилгах	- Тоосролт бургиаг арилгана.	2023онд	1,200.0		

бороожуулагч дээр урсгал завсар хийх	Тоосжилтыг бууруулна, тоосролт бургиаг арилгана.		Үйл ажиллагааны зардалд тусна.	Засварын инженер Засварын хэсэг	
➢ Бутлагч дээр цэвэр ус татаж бороожуулагч тавих ➢ Өмнө байгаа бороожуулагчийг их засварт оруулах					
Түлш дамжуулах хэсэгт хашаа барих ба нарийн үнсний хашааг битүүмжлэх. ➢ Зуухнаас гаргасан циклоныг битүүмжүүлэх	Түлш дамжуулах хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулна.	2023 онд	Хөдөлмөр хамгааллын зардалд тусна		
- Дуу чимээ ихтэй орчинд ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах - Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ашиглалтад хяналт тавих	Ажиллагсдын эрүүл мэнд болон дуу шуугианы нөлөөлөлд өртөхөөс хамгаалах.	2023онд	Хөдөлмөр хамгааллын зардалд тусна.	Химийн инженер ХАБЭА-гийн инженер	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
➢ Итгэмжлэгдсэн лаборатораар Агаарын шинжилгээ хийлгэх	Орчны агаарын	Жилд 1 удаа	500.000₮	Химийн инженер	

➤ Шилжилгээний дагуу арга хэмжээ авч ажиллах	бохирдлыг багасгах			БОАХмэргэж илтэн	
2. ГАЗРЫН ГАДРГА БА ХЭВЛИЙ					
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Хугацаа ба давтамж	Нийт зардал, мян.төг	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал
Үнсэн сангийн талбайг зөвшөөрөлтэй хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	Газрын эвдрэлээс зайлсхийнэ.	2023 онд	Зардал тооцох шаардлагагүй	ХАБЭА-н инженер	Газрын тухай хууль: Зүйл 50-1.1, 1.2; 55-2,3,4,5 "Байгаль орчныг хамгаалах тухай" хууль: Зүйл 25-2; "Газрын хэвлийн тухай" хууль: Зүйл 41-1, 2, 3, 4;
Станцын эзэмшлийн талбайд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэж, хяналт тавих	Газар ашиглалт, зохион байгуулалтыг сайжруулах, эмх цэгцтэй болгох.	2023 онд		Химийн инженер Дэд захирал	
Үнсэн сангийн тогтвортой байдлыг хангаж үерийн суваг шуудуу татах ➤ Цэвэрлэгээ хийх ➤ Хашааг нөхөж татах	Газрын тогтвортой байдлыг хангана.	2023 онд	Хог хаягдлын хэсэгт тусгасан	Ашиглалтын инженер	
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх	Газар эзэмшлийг хянах	2023 онд	БОХ зардалд тусгасан	БОАХ мэргэжилтэн Химийн инженер	

Мэргэжилийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, арга хэмжээ авч ажиллах	Орчны бохирдлоос сэргийлэх	2023оны хаврын улиралд	Хог хаягдлын хэсэгт тусгасан	Ашиглалтын инженер Химийн инженер	
3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС					
Хар Нуур-Ховд голын сав газрын захиргаанаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	Усны зарцуулалтын хэмжээ болон төлбөр тооцох хувь хэмжээг тооцох	2023 онд 1-р сард	3. 000.0	Химийн инженер	“Усны тухай” хууль, “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. “Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
Баян-өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Усны зарцуулалтын хэмжээг хянах				
Усны шинжилгээг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллах	Усны чанарт гарсан өөрчлөлтийг богино хугацаанд илрүүлэх боломжтой болох	Үйл ажиллагааны явцад	400.0	Химийн инженер	
Хаягдал усны сангийн даланг сэргээх	Орчныг бохирдуулахаас сэргийлэх			ХАБЭА-ийн инженер	
Хаягдал усан санд геомембран хальс дэвсэх	Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор	2023-2024		Ерөнхий инженер	

Газрын доороос ус татах эх үүсвэрийн цооногууд дээр усны тоолуур тавих ➤ Тоолууруудад баталгаажуулалт хийлгэх	Усны ашиглалтын хэмжээг хянах				
Усны шинжилгээний үр дүнгээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах төлөвлөгөө гаргаж ажиллах	Усны чанарт гарсан өөрчлөлтийг хянаж, сайжруулах арга хэмжээг нэн даруй авах	Ажил үүргийн хуваарийн дагуу			
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Хугацаа ба давтамж	Нийт зардал, мян.төг	Хариуцах эзэн	Баримтлах стандарт, аргачлал

4.ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, доройтлыг хянаж байх хяналт мониторингийн ажлыг тасралтгүй явуулах	ДС-ын ашиглаж байгаа 3.24 га талбайн хөрсөн бүрхэвч үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтох нь багасах.	2023 онд	ОХШХ-т тооцсон	ХАБЭА-н инженер	“Газрын тухай” хуулийн 55 дугаар зүйл, MNS 5850:2008. “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 3473:1993. “Газар
Нүүрсний агуулах болон станц орчмын нүүрсний хаягдлаар бохирдсон	Хөрс, ургамлан нөмрөгийг эвдрэлд оруулж доройтуулахгүй	2023 онд	Хог хаягдлын хэсэгт	Ашиглалтын инженер	

газрын хэмжээг цаашид нэмэгдүүлэхгүй байх	байх нөхцөл бүрдэнэ.	2023 онд	тооцсон.	Ашиглалтын инженер Засварын хэсэг	ашиглалт. Нэр томъёо, тодорхойлолт” MNS 5914:2008. “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт Аюулгүй ажиллагааны дүрмийг сайтар баримтлах
Хог хаягдрыг ангиллын сав хийж байршуулах	Станцын үүдэнд зтерлийн ахуйн хог хаягдал ялган ангилах сав хийж өгсөөр хог хаядлыг хураахад амар бас орчныг бохирдуулахгүй байх		500.000		
Хөрсний шинжилгээ хийлгэх	Урьдчилан сэргийлэх	2023онд	500,000	Химийн инженер	
Хаягдал усан сан орчмын хөрсөнд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж байх	Станцын ойр суурьшсан айл өрх, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ.	2023 онд	800.0	Химийн инженер	
Зуухнаас гарч байгаа бохирдуулагч бодисууд хөрсөнд нэвчиж, хөрс бохирдохоос сэргийлж хаягдлын санд геомембран хальс дэвсэх шаардлагатай.	Орчны газрын хөрс бохирдохгүй байх болно.	2023 онд	Хог хаягдлын хэсэгт тооцсон.	Ашиглалтын инженер, химийн инженер	

5.УРГАМАЛЫН НӨМРӨГ

Дулааны станцад ногоон байгууламжуудыг өргөтгөх, нэмэж 300 мод	Орчны ногоон байгууламжийн тохижилт сайжирна.	2023 онд	ИТА, захиргаа	
--	---	----------	---------------	--

тарих			Нөхөн сэргээлтийн хэсэгт тооцсон	ИТА, захиргаа	
Зүлэгжүүлэлтэд зориулж ф50-н шугам 50м, ф32-н шугам 120 м-ийг худгаас татаж зүлэг услах	Орчны ногоон байгууламжийн арчилгаа сайжирч, ногоон байгууламжийг чадавхи дээшилнэ.	2023 онд			
ЭКО ОО хийх	Ургамал, ус,агаар,хөрсний эвдрэл бохирдлоос сэргийлэх	2023 онд	БО-ийг хамгаалах зардлаас гаргах	ИТА, захиргаа	Стандартын дагуу мэргэжилийн байгууллага болон хувь хүнээр
6. ОРШИН СУУГЧИДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ					
Станцын нөлөөллйн бүсэд нэмж газар олголт хийлгэхгүй талаар арга хэмжээ авах			Тусгай сан үүсгэх хэрэгтэй	Дэд захирал	тушаалаар баталсан “БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах тухай” журам
Станцын ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, ажиллагсдад үзүүлэх нөлөөллийг бууруулах	жилд 1 удаа	800 000	Захиргаа	
нийт зардал			8.108.000		

БОМТ-нд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзсэн бөгөөд сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд 8.108.0 мянган төгрөг шаардлагатай байна.

3.2.1 Ногоон бүс зохион байгуулах арга хэмжээ

Ажлын хэмжээ: Өлгий дулааны станцын эзэмшлийн талбай дотор болон гадна талд 3 хэсэг газарт ногоон байгууламжийг тохижуулна. Үүнээс эзэмшлийн талбай дотор 3 хэсэг нь одоо байгаа ногоон байгууламжийг сайжруулах болно.

Нийт ногоон байгууламжийн хэмжээ ойролцоогоор 0.45 га болох бөгөөд одоогийн байгаа 20-30 настай улиаснууд дээр нэмээд 60 орчим мод, сөөг тарих боломжтой. Шинээр тарих модны төрөлд Өлгий хотын цаг уурын нөхцөлд зохицох чадвартай улиас, тэмээн харгана сонгох нь зүйтэй.

Станцын орчны ногоон бүсийн тохижилтод арчилгааг сайжруулахад усалгаа хийх зорилгоор ф50-н шугам 50м, ф32-н шугам 60 м, нийт 120 м урт усны шугам татна. Энэ нь БОМТ-ний тайлант хугацаанд хийж гүйцэтгэх боломжтой ажил юм.

Ногоон бүс тохижуулах ажлын зардал.

Ногоон бүс тохижуулах ажлыг ихэвчилэн гараар хийнэ. Мод сөөгийг суулгах нух ухах, мод сөөгийг тээвэрлэн авчирч суулгах нүхэнд ойртуулж тараах, сулгах зэрэг ажлууд үндсэндээ гар ажиллагаатай байна. Мөн шимт хөрсний овоолгод ургамлын үрийг гараар суулгана. Тиймээс энд голдуу гар ажлын зардал тооцсон бөгөөд ажлын бүтээлийн нормыг ХАА-н үйлдвэрлэлд жимс, жимсгэний мод сөөг тарих ажлын нормчилсон үзүүлэлтээр авсан болно.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дахь “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн Дулааны станцын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2019 он Байгаль орчны судалгаа, үнэлгээний зөвлөх “Байгаль-Экологи” ХХК-д боловсруулсан. Харин ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ажлын

өдөрт шилжүүлсэнийг 2 дахин өсгөж тооцоход ногоон бүс байгуулах ажлын нийт зардал 2.039.0 сая төгрөгөөр тооцогдож байна.

3.3.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Дулааны станцын хог хаягдлын хэмжээ. 50-иад жилийн түүхтэй Өлгий хотын дулааны станцын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэнээр жилд станцаас нийт 18.0 мян.тн хог хаягдал гарахаас 28.0 хувь нь ахуйн хаягдал байна.

Тус станц нь үйлдвэрлэлд жилд 21,190.0 м3 ус ашиглахаас унд-ахуйн хэрэгцээнд 630 м3 , дулаан үйлдвэрлэхэд 20.56.00 м3 ус ашиглана. Нийт ашиглах усны 94 орчим хувийг эргэлтээр ашиглах бөгөөд жилд дунджаар 3.56 м3 ахуйн бохир, 5.00 мян.м 3 үйлдвэрлэлийн бохир усыг гадагшлуулах ба энэ нь нийт ашигласан усны 2.26 хувь болж байна. Энэ нь жилд Өлгий хотын бохир усны шугамд нийт ,12.56,00 м3 ус нийлүүлэх бол, хаягдлын сан руу нийт 5,00 мян.м 3 бохир шингэн хаягдлыг гаргана.

Станцаас жилд 8,8 мян.тн үнсэн хаягдал гарах бөгөөд түүнийг барилгын материал (цемент) үйлдвэрлэхэд үндсэн түүхий эд болгон ашиглах технологийн судалгааг төсөл хэрэгжүүлэгч хийж байгаа учраас хоёрдогч түүхий эд болгон ашиглана гэж үзэж байна.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Хэмжих нэгж	жилд гарах хэмжээ	Дахин боловсруулах	Хадгалах	Устгах	Ландфилл хийх	Хоёрдогч түүхий эдэд нийлүүлэх
Ахуйн	Нийтийн хоолны	т03 99		мян.тн	0.008				0.008	

	Ахуйн бохир ус м3 37.8 37.8			м3	5.00	5.00				
	Ахуйн хатуу хаягдал			мян.тн	0.32				-	
	Ахуйн бусад хаягдал	С 01 99	ба га	мян.тн	-					
Үйлдвэрийн	Сав баглаа боодлын хаягдал	О 01			+					
	Ашиглалтаас гарах дугуй	Ө 01 01			+			+		
	Ашиглалтаас гарах автомашин	Ө 01 01*	ду нд		+			+		+
	Тосны шүүлтүүр	Ө 01 04*	их					+		+
	Тос агуулсан хаягдал	Ө 07 01*	ду нд		+			+		
Аюултай, хортой	Тэсрэх бодисын хатуу хаягдал		их	мян.тн	-					
	Үйлдвэрийн хаягдал ус	С 09 99	их	мян.ку б.м	5.00				5.00	
	Тэсрэх бодисын задралын хий		их							
	Хаягдал даавуу		их	мян.тн	-					

2.3.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөлт. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанаас эх үүсвэрийн хувьд ахуйн болон үйлдвэрлэлийн, мөн ангиллын хувьд хатуу болон шингэн хог хаягдал гарна. Ахуйн хог хаягдлын асуудал нь суурин газрын хог хаягдлын нэгдсэн менежментээр шийдэгдэж байх тул төсөл хэрэгжүүлэгч үйлдвэрлэлийн хог хаягдалтай холбоотой асуудлаар менежментийн төлөвлөлт хийж хэрэгжүүлэх шаардлагатай болно. Үүнд:

- Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг хоёрдогч түүхий эдэд нийлүүлэх боломжтой болох хүртэл үнсэн сангаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн хадгалж, хуримтлуулах шаардлагатай болно.
- Үйлдвэрлэлийн шингэн хаягдлыг хуримтлуулах лагийн талбайг технологийн аюулгүй байдалд ашиглах нөхцөлийг бүрдүүлэхдээ байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Үйлдвэрлэлийн хатуу хаягдлын аюулгүй байдлыг хангах. Үнсэн сангийн тогтвортой байдлыг найдвартай хангахын тулд үнсэн овоолгын хормойн хэсгийг гадаргын урсацаас хамгаалж, уулнаас ирэх уруйн урсацад чиглэлийн тохиргоо хийх хэрэгтэй байна. Үүний тулд зурагт үзүүлснээр уруйн урсац орж ирэх боломжтой хамгийн их урсацтай голдирлыг үнсэн овоолгын захаас холдуулж засах хэрэгтэй бөгөөд үерийн хамгаалалтын шуудуу нь амсраараа 60-70 см өргөн, сууриараа 35-40 см өргөн, гүн нь 0.7 м байх нь зохимжтой. Ийм хийцийн хамгаалалтын сувгийг үнсэн овоолгоос дээш 15 хүртэл м-ээс эхлэх бөгөөд нийт сувгийн урт 50 м-ээс багагүй байна.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажлын хэмжээ. Тус станцын хувьд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд үүссэн хог хаягдлыг зайлуулах, түр болон бүр хугацаагаар хуримтлуулан хадгалах 2 шийдэлтэй байна. Станцын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын хэмжээ, тэдгээрийн эх үүсвэр болон ангиллын байдлаас үзвэл станцаас гарах нийт 18 мян.тн хог хаягдлын 27.15 хувийг хог хаягдлын төвлөрсөн цэгт зайлуулах, 52.4 хувийг ландфиллын аргаар булшлах, 34.7 хувийг хоёрдогч түүхий эдэд нийлүүлэх нөхцөлтэй байна.

Үүссэн хог хаягдлыг хадгалалтын хугацаагаар нь авч үзвэл төвлөрсөн цэгт зайлуулах хог хаягдлыг богино хугацаагаар хадгалж, тухай бүр зайлуулж байх бол ландфиллд хийх хог хаягдлын 97.3 хувийг 1 жилээр, хоёрдогч түүхий эдэд нийлүүлэх хаягдлыг урт хугацаагаар хадгалах болж байна.

Эндээс тодорхой хугацаагаар хадгалах хог хаягдлын хадгалалтын нөхцөлийг сайжруулахад үнсэн сан болон хаягдлын сангуудыг тохижуулж, найдвартай болон аюулгүй байдлыг нь хангаснаар хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой.

№	Хийгдэх ажил	Ажлыг төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ
1	Ахуйн хог хаягдлыг зайлуулах	Тээвэр	Мян.тн	8.3
2	Үндсэн сангийн хамгаалалтын шудуу хийх	Газар шорооны ажил	М³	700м³ 0.7*1.5м=735
3	Хамгаалалтын шудууны арчилгаа	Газар шорооны ажил	М³	500
4	Хаягдсал сангийн далангийн тохижуулалт	Газар шорооны ажил	М³	250м³*0.3м *0.7м=52,5
5	Хаягдлын санд плёнк дэвсэх	Газар шорооны ажил	га	0.45

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал. Хог хаягдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардалд төсөл хэрэгжүүлэгч өөрийн үйл ажиллагаандаа жилд дунджаар 1,200.0 мянган төгрөг зарцуулдаг бөгөөд энэ нь жилд 1.200.0 мянган төгрөг болж, БОННУ-нд ахуйн хог хаягдалд нэмэлт зардал тооцох шаардлагагүй байна. Мөн энэ удаагийн БОННУ-ний үйлчлэлийн хугацаанд төсөл

хэрэгжүүлэгчид үнсэн санг хаах шаардлага үүсэхгүй тул түүнтэй холбоотой үйл ажиллагаанд зардал тооцох шаардлага гарахгүй юм.

Хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, мян.төг	Баримтлах хууль, стандарт, аргачлал
1	Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн цэг рүү зайлуулах	Үйл ажиллагааны зардалд тусгасан	“Хог хаягдлын тухай” хууль “Эрүүл ахуйн тухай” хууль:
2	Үнсэн сангийн хамгаалалтын шуудуу хийх		
3	Хаягдлын сангийн далангийн тохижуулалт		
4	Хамгаалалтын шуудууны арчилгаа хийх	77.2	
5	Хаягдлын санд геомембран дэвсэх	771,6	
6	Нийт дүн	848.8	

3.3.4 Осол, эрсдэлээс хамгаалах менежментийн төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх менежмент. Дулааны станцын технологийн үйл ажиллагаанаас үүдэн тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх, гал түймэр гарах зэрэг эрсдэл гарах болзошгүй тул осол, эрсдэлийг урьдчилан тооцох, дотоод хяналтыг байнга тавих, ослын үед яаралтай арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай материал болон авран хамгаалах хэрэгслийн нөөцийг хангаж, ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт явуулан, үйл ажиллагаанд дотоод хяналт тавих үүрэг “Дотоод хяналтын алба” болон ХАБЭА-н инженерт тавигдана. Станц нь осол эрсдэлээс хамгаалахад хөдөлмөр хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна мөн объектын харуул, хамгаалалтыг онцгойлон анхаарч тодорхой зардал төлөвлөдөг байна.

4	Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах;	200.0	
5	Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	300.0	“Галын аюулгүй байдлын тухай” хууль, MNS 4244:1994 Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
дүн		500,0	

3.3.6 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Удирдлагын менежмент. Төслийн хөдөлмөрийн нөөцийн бүтцэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны хяналт үнэлгээг гүйцэтгэх захирлын шууд удирдлаган дор “Дотоод хяналтын алба” ажиллаж байна.

Тус албаны үндсэн үүрэг осол дөхсөн тохиолдлыг ослоос өмнө илрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах явдал болно. Ер нь бол удирдлагын нэгжид ХАБ болон БОХ-ын асуудал хариуцсан нэгж хэсэг ажиллах шаардлагатай бөгөөд энэ нь байгаль орчны хамгааллын асуудал, хяналт мониторинг, БОМТ-ний хэрэгжилтийн хангаж ажилладаг.

“Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу дулааны станцын шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоож, нөлөөллийн шууд бүсэд байгаа станцтай хаяа дэрлэн амьдарч байгаа айл өрхийг дахин төлөвлөлт хийж бохирдлын бүсээс гадагш гаргах хэрэгтэй. Энэхүү ажил нь суурьшлаа солихыг хүссэн өрхүүдэд шинэ суурьшлын газар олгох, нүүлгэн шилжүүлэлтийг Өлгий сумын захиргаатай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд холбогдох зардлыг тухай бүр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан шийдэх шаардлагатай болно.

Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөг байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, байгаль хамгаалах арга хэмжээний

тайланг жил бүр батлуулж, үр дүнг тооцуулахаас гадна төсөл хэрэгжүүлэгч нь 2 жил тутам байгаль орчны аудит, 5 жил тутам газрын чанарын төлөв байдлын хянан батлагаа, БОННУ-ний нэмэлт тодотголуудыг хийж байх болно.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дахь “Эрчимбаян-Өлгий” ХК-ийн Дулааны станцын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2019 он Байгаль орчны судалгаа, үнэлгээний зөвлөх “Байгаль-Экологи” ХХК-д боловсруулсан.

Удирдлага, зохион байгуулалтын зардал.

БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын нийт зардал 2 000.0 мянган төгрөгөөр тооцогдож, түүний дийлэнх нь “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасанчилан төслийн үйл ажиллагаанд 2 жил тутамд байгаль орчны аудит хийхэд зориулагдана.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, мян.төг	Баримтлах хууль, стандарт, аргачлал
1	ИТА, ажилчдад хууль тогтоомж, аюулгүй ажиллагаа зааварчилгаа болон байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах;	Үйл ажиллагааны зардалд туссан	Засгийн газрын 311 дүгээр тогтоол.
2	Дулааны станцын шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг шинэчлэн тогтоох	1000 000	“Эрчим хүчний тухай” хуулийн 33-р зүйл
3	Байгаль орчны аудитын зардал, 2 удаа		“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 101 дүгээр зүйл

4	Станцын салхин доорхи зарим айл өрхүүдийг бохирдлын бүсээс гадагш байршуулах	Тусгай хөтөлбөр, боловсруулах	
	НИЙТ ДҮН	1 000 000	

6.4 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Өлгий дулааны станцын үйл ажиллагааны явцад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарах өөрчлөлтийг тодорхойлох зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүнийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолж, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-ийг боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу орчны хяналт-шинжилгээний ажлын зардлыг гаргаж, батлагдсан аргазүй, итгэмжлэгдсэн лабораториудыг ашиглан явуулна. Хяналт-шинжилгээний ажлын үр дүнгүүдийг нэгтгэн, жил бүр холбогдох төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сумдын холбогдох албадад хүргүүлж байхаас гадна орон нутгийн оршин суугчдад хяналт, шинжилгээний үр дүнгээр мэдээлэл бэлтгэн хүргэж байх болно.

6.4.1 Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд

Уур амьсгал, агаарын чанарын үзүүлэлтүүд. Тухайн төслийн талбай орчмын бүс нутгийн цаг уурын үндсэн үзүүлэлтүүд болох агаар болон хөрсний температур, харьцангуй чийг, салхины хурд ба чиглэл, нарны цацраг, хур тунадасны хэмжээ, ууршилт зэргийг төслийн үйл ажиллагааны хугацаанд тогтмол

хянаж байх болно. Төслийн үйл ажиллагааны явцад агаарын чанарын хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах асуудлыг хамруулна.

Үүнд:

- Тухайн нутаг дэвсгэр дэх газар ашиглалт, тээврийн үйл ажиллагаатай холбоотой бий болох бүс нутгийн тоосжилтын агууламжуудыг тогтоох суурь мэдээллийг цуглуулах ажлыг үргэлжлүүлэн хийх;
- Дулааны станц болон түүний ойр орчим дахь тоосжилтын агууламж нь байгаль орчны болон эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх мэдээллийг холбогдох талуудад өгөх;
- Бохирдлын цэгэн эх үүсвэрүүдээс ялгарч буй бохирдуулагчид нь төлөвлөлтөд заасан хэмжээнд байгаа эсэхийг шалгах;
- Агаарын чанарын менежментэд тус дөхөм болох, таамаглалын загваруудыг сайжруулахад шаардлагатай цаг уурын урт хугацааны мэдээллээр хангах зэрэг орно.

Гадаргын болон газрын доорх усны хяналтын үзүүлэлтүүд. Төслийн үйл ажиллагааны явцад тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, эдэлгээний хугацаа зэргээс шалтгаалан бохир шингэн хөрсөнд алдагдаж, улмаар гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй. Цаашдын үйл ажиллагааны явцад хог хаягдлыг түр хадгалах цэгийг зөв байршуулах хэрэгтэй.

Газрын доорх усны түвшин. Газрын доорх усны түвшний бууралт бий болох, түүний гадаад бүсэд газрын доорх усны түвшнийг хянаж байх шаардлагатай. Хяналтын цооногуудыг энэ тайланд зааснаар болон мэргэжилтний заавраар сонгох шаардлагатай.

Газрын гадарга ба хөрсний хяналтын үзүүлэлтүүд. Агаар, ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгийг бохирдуулагчийн хэмжээг урт хугацааны туршид ажиглалт, хэмжилт хийхийн зэрэгцээ хөрсний мониторинг цэгүүдийн байршлуудыг

тогтоох, мөн хөрсний үндсэн шинж чанарын үзүүлэлтүүд, бохирдолт, элэгдэл эвдрэлийн төлөв байдлыг тогтоох ажлыг хийж байх шаардлагатай.

Хөрсний мониторингийн цэгүүдээс жилд (хавар, намар) 2-оос доошгүй удаа хөрсний дээж авч, лабораторийн задлан шинжилгээгээр хөрсний ерөнхий үржил шимийн түвшин болон бохирдол тодорхойлож байх болно.

Эрүүл ахуйн хяналт-шинжилгээ. Хоргүй нөхцөл гэдэг нь өдөр бүр, ажлын 8 цаг буюу долоо хоногт 40 цагаас их биш хугацаагаар ажилласан бүх хугацаанд хүний эрүүл мэндэд тухайн үед болон хожим үр удамд нь ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй болох нь нотлогдсон хэмжээг хэлдэг.

Ажлын байрны агаарын орчинд агаарын хэм, хөдөлгөөний хурд, чийгшил, дулааны тархалтын үзүүлэлт тус тус хамаарна. Ажлын байрны температур нь хүйтний улиралд 10°C-ээс их, дулааны улиралд 10°C-ээс бага байна. Хэмжилтийг шалнаас дээш суугаа ажлын үед 1 м, зогсоо ажлын үед 1.5 м өндөрт хэмжинэ.

3.4.2 Хяналт, шинжилгээний хөтөлбөр

“Эрчимбаян-Өлгий” ХК-ийн дулааны станцын үйл ажиллагааны явцад байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх бөгөөд үүнд нийт 2,100,000 мянган төгрөгийн зардал төлөвлөв.

БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний зардал

2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөөг хэрэгжүүлэхэд нийт **16,550,000 төгрөг**, үүнээс байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд **12 397000 төгрөг**, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **2,100,000 төгрөг** тус тус зарцуулахаар төлөвлөв.

ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГИЙН ХАВСАРЛТ

Баян-Өлгий аймгийн "ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ" ХК-ийн Дулааны станцын 2022 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн товч танилцуулага

Тус дулааны станц нь 2019 онд Байгаль орчны судалга үнэлгээний "Байгаль-Экологи" ХХК-аар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж хэрэгжүүлсэн ба Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг аймгийн засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгээр дүгнүүлэн төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Мөн БОМТ-г жил бүр БОАЖЯ-ны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газраар баталуулан хэрэгжүүлэн ажиллав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө \БОМТ\ нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих, орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго болгож ажилсан.

Өлгий дулааны станцын үйл ажиллагааны явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэх дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцлөөр бүрдүүлэн ажиллав.

Байгаль орчны аудитыг 2022 онд Увс аймгийн эрх бүхий "МӨСТИЙН РАШААГ"ХХК-аар 7,000,000₮ хийлгэж түүний дагуу төлөвлөгөө гаргаж ажиллаж байна.

Нүүрсний тортогны бургиаг багасгах бороожуулагчийг сайжируулах, эерэг арга хэмжээ авч, ажлын байрны нөхцлыг сайжруулж 650,000₮ зарцуулав.

Хаягдлын санд ариутглыг жилд 2-3 удаа хийлгэж, 390,000₮, сатнцын ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамааруулж 600,000₮, ногоон бүсийг усалгаатай

болгох шугам хоолой тавих ажилд 625,000₮, ногоон байгууламж үүсгэх зорилгоор мод суулгах, ойжуулах хүрээнд 700,000₮ тус2 зарцуулсан болно.

Станцын орчны суурьшлын бүсэд байгаа айл өрхүүдэд сурталчилгаа хийж \ирсэн гомдол санлын дагуу арга хэмжээ авч \ажилсанд 200,000₮ хэрэглэв.

Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн цэг рүү зайлуулах, хаягдлын сангийн далангийн тохижуулалт, хаягдлын сангийн арчилгаац, цэвэрлэгээ зэрэг ажлуудад 3,0₮ зарцуулсан.

Увс аймгийн итгэмжлэгдсэн лабораторт төв зуух болон салбар зуухнуудын ус,агаар,хөрснөөс шинжилгээ хийлгэж тэрний дагуу арга хэмжээ авч нийт 1,200,000₮ зарцуулан ажиллаж байна.

Аймгийн БОАЖГ-т ус ашиглах гэрээ, ХАРНУУР Ховд голын сав газрын захиргаанаас 2022 оны ус ашиглах дүгнэлт гаргуулан нийт 1,500,000₮ зарцуулан ажиллав.

Аймгийн Хот тохижилтын газартай хамтран ажиллах гэрээ байгуулж хог хаягдлын төлбөрийг цаг тухайтан төлж ажиллаж байна.

Зуухнаас гарсан үнс циклоныг өөрийн унаагаар өлгий сумын зааж өгсөн газарт нь хүргэж тогтмол цэвэрлэгээ хийж ажиллав.

Агаарын чанрын шинжлгээ хийлгэх хаягдал утааны шинжилгээ хийлгэх, ажилчдыг эрүүл мэнд үзлэгт оруулах зэрэг төлөвлөгөөнийхээ дагуу хийгдсэн ажилуудад 1,800,000₮ зарцуулсан байна.

Аймгийн ҮЭХолбоо, ХХГазруутай хамтран ажиллаж мэргэжилийн хүмүүсээр Байгаль орчны асуудал орчны цэвэрлэгээ болон нийт ажилчдыг хамтарсан сургалт семинар зохион байгуулла. Иймд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2022 онд 12,005,000₮ төлвөлсөн ба биелэлт нь 17,000,000₮ болно.

"Эрчимбаян Өлгий" ХК Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-НИЙ 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт:Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ / нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Өлгий дулааны станцын үйл ажиллагааны явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн. БОМТөлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцлөөр бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

1. АГААРЫН ЧАНАР

Хийгдэх ажил	Гарах үр дүн	Хугацаа ба давтамж	Нийт зардал, мян.төг	Биелэлт
Утаа системүүдийн хэвийн ажиллагааг хангах	Хүрээлэн буй орчны агаарын чанарт станцын яндангаас хаягдах агаар бохирдуулагчдын үзүүлэх нөлөө багасах	2022 онд	Үйл ажиллагааны зардал тусгасан. .	➤ К2,К3-р зуухны болон нүүрс дамжуулах хэсгийн батерийн циклоныг шинээр солиж тавьсан. Мөн түлш дамжуулах конверт бороожуулалт хийж циклон болон бургиаг наамдаж ажиллаж байна.
Нүүрс тээвэрлэлт болон үнс зайлуулах системийг хамгийн	Станцын талбайгаас хаягдал үнс, нүүрсний тоос салхиар дэгдэж орчны	2022 онд	Үйл ажиллагааны	

зохимжтойгоор шийдвэрлэх	агаарын чанарт үзүүлэх нөлөө багасна	2022 онд	зардалд тусна.	
БУШ зуухнаас гарсан үнснийг яндангийн дор хонхор гаргаж, түүнийг норгож байх	- Бургиа үүсэхгүй болно.	2022 онд	Зардал тооцох шаардлагагүй	➤ Өвөлийн бэлтгэл нүүрс болон үнс зөөдөг том тэрэгнүүдийг эзэмшлийн талбайд орж гарах үед нэгэл замаар явуулж байна. Байгаль орчны асуудал хариуцсан хүнийг орон тоонор хангаж хянуулан ажиллаж байна.
Түлш дамжуулахын салхилуураас гарах бургиаг арилгах бороожуулагч тавих	- Тоосролт бургиаг арилгана.	2022 онд	1,500.0	➤ Бороожуулалт хийсэн.
Бутлагч дээр цэвэр ус татаж бороожуулагч тавих	Тоосжилтыг бууруулна, тоосролт бургиаг арилгана.	2022 онд	Үйл ажиллагааны зардалд тусна.	➤ Бутлагч болон түлш дамжуулах хэсэгт хүйтэн ус орох хоолой татаж бороожуулагч хийж өгсөн.
Түлш дамжуулах хэсэгт хашаа барих ба нарийн үнсний хашааг битүүмжлэх.	Түлш дамжуулах хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулна.	2022 онд	Хөдөлмөр хамгааллын зардалд тусна	➤ Түлш дамжуудах хэсэгийн хашааг дахин янзлаж барьсан. Өмнө үерийн улмаас аймгийн Онцгой байдал, засаг даргын шийдвэрээр эвдсэн хашааг өөрийн хөрөнгөөр

				манай байгууллага өөрөө янзалсан ➤ Зуухнаас гарсан циклоныг нэгэл газарт оволж байгаад 7хоногт нэг удаа хогын цэгт ачиж цэвэрлэж байна.
- Дуу чимээ ихтэй орчинд ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах - Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн ашиглалтад хяналт тавих	Ажиллагсдын эрүүл мэнд болон дуу шуугианы нөлөөлөлд өртөхөөс хамгаалах.	2022 онд	Хөдөлмөр хамгааллын зардалд тусна.	➤ Байгууллагын нийт ажилчдыг цаг тухайтан аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт оруулж байна. ➤ Дуу чимээ ихтэй орчинд ажилдаг ажилчдыг байгууллагын дотоод журам буюу хөдөлмөр хамгаалалын хуулийн хүрээнд ХХХ-ээр хангаж байна. Аль болох дуу чимээ ихтэй тоног төхөөрөмж дээр зөөлөн холбоо болон өөрийн стандартын дагуу засвар хийж өгч дуу чимээг багасгаж ажиллаж байна.

2. ГАЗРЫН ГАДРГА БА ХЭВЛИЙ

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга	Гарах үр дүн	Хугацаа ба давтамж	Нийт зардал, мян.төг	Биелэлт
--	--------------	--------------------	----------------------	---------

ХЭМЖЭЭ	Газрын эвдрэлээс зайлс хийнэ.	2022 онд	Зардал тооцох шаардлагагүй	Өлгий суын захиргаанаас зааж өгсөн газарт нь зуухнаас гарсан хаягдлыг өөрийн унаагаар 7хоногт нэг удаа тээвэрлэж тус хогын цэгийг хашаалж төмөр утсаар\ татаж мал амьтан орохгүй болгосон. Мөн хогын цэгийн эмх цэгц байдлыг хангаж ажиллав.
Үнсэн сангийн талбайг зөвшөөрөлтэй хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	Газрын эвдрэлээс зайлс хийнэ.	2022 онд	Зардал тооцох шаардлагагүй	Өлгий суын захиргаанаас зааж өгсөн газарт нь зуухнаас гарсан хаягдлыг өөрийн унаагаар 7хоногт нэг удаа тээвэрлэж тус хогын цэгийг хашаалж төмөр утсаар\ татаж мал амьтан орохгүй болгосон. Мөн хогын цэгийн эмх цэгц байдлыг хангаж ажиллав.
Үнсэн сангийн талбайд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэж, хяналт тавих	Газар ашиглалт, зохион байгуулалтыг сайжруулах, эмх цэгцтэй болгох.	2022 онд	4,000,000	2022оны 11-р сард Улаанбаатар хотоос эрх бүхий мэргэжилийн компаниар газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэв. одоо түүний дагуу 2023онд төлөвлөгөө гарган ажиллаж байна.
Үнсэн сангийн тогтвортой байдлыг хангаж үерийн суваг шуудуу татах	Газрын тогтвортой байдлыг хангана.	2022 онд	Хог хаягдлын хэсэгт тусгасан	Увс аймгийн эрх бүхий "МӨСТИЙН АРААШАН" ХХК-аар аудитын тайлан гаргуулан ажиллаж байна. Энэ ажил 2022онд багтааж хийж чадаагүй болохоор 2023 хийхээр дахин төлөвлөн ажиллаж байна.

3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС

Хар нуур-Ховд голын сав газрын захиргаанаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	Усны зарцуулалтын хэмжээ болон төлбөр тооцох хувь хэмжээг тооцож өгөх.	2022оны	1 000.0	“Усны тухай” хууль, “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. “Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982 стандартын дагуу дүгнэлт гаргуулж аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Гүлжанаар ус ашиглах гэрээ байгуулан зөвшөөрөл авч ажиллаж байна. .
Баян-өлгий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Усны зарцуулалтын хэмжээг хянах боломжтой болно.			
Усны шинжилгээг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллах	Усны чанарт гарсан өөрчлөлтийг богино хугацаанд илрүүлэх боломжтой болох	Үйл ажиллагаа ны явцад	Зардлыг ОХШХ-т тусгасан	Тус компаны Химийн инженер БОАХМ-тэн усны шинжлгээг Увс аймгийн итгэмжлэгдсэн лаборатораар хийлгэж үр дүнгийн үзүүлэлтийн дагуу төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Үүнд: Ус зөөлрүүлэх филтр, ус хийгүүжүүлэх төмрийн үртсэн деаэраторийг шинээр суурилуулан ажиллаж байна. Мөн усны эх үүсвэр дээр тоолуур суурилуулан аймгийн Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуудсан байна.
Газрын доороос ус татах эх үүсвэрийн цоонууд дээр усны тоолуур тавих	Усны ашиглалтын хэмжээг хянах			Аймгийн эрх бүхий “СУАТ”ХХК-бн мэргэжилийн хүмүүсээр усны эх үүсвэр дээр тоолуур суурилуулан аймгийн Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулан жил болгон Ховд гол Сав газрын захиргаанд

нэмэгдүүлэхгүй байх			тооцсон.	ангиас нийт 550ш мод авч ажилтыг дайчлан суулгаж зууны улиралд услахаар хүн ажилд авч ажиллуулав.
Хаягдал усан сан орчмын хөрсөнд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийж байх	Станцын ойр суурьшсан айл өрх, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ.	2022 онд	600.0	Хаягдал усан сан болон байгууллагын нийт хэмжээнд халдвар ариутгалжуулалтыг аймгийн эрх бүхий "Өлгий ариутгал"ХХК"-аар хийлгэж хамтран ажиллах гэрээ байгуулсан.
Зуухнаас гарч байгаа бохирдуулагч бодисууд хөрсөнд нэвчиж, хөрс бохирдохоос сэргийлж хаягдлын санд геомембран хальс дэвсэх шаардлагатай.	Орчны газрын хөрс бохирдохгүй байх болно.	2022 онд	Хог хаягдлын хэсэгт тооцсон.	Нэгэл газар хадгалан ачуулж байна. Энэ жилийн ажилд багтаагүй бохоор 2023оны БОМТ-д дахин оруулж хийхээр төлөвлөж байна.
5.УРГМАЛЫН НӨМРӨГ				
Дулааны станцад ногоон байгууламжуудыг өргөтгөх, нэмэж 120 мод тарих	Орчны ногоон байгууламжийн тохижилт сайжирна.	2022 онд	Нөхөн сэргээлтийн хэсэгт	2022оны хавар болон намар нийт 100ажилтан 550ш модыг байгууллагын эзэмшлийн газрын 10%-тай тэнцэх хэмжээний газар болон өөр газарт тарьсан. Мөн хүн авч услах ажил хийлгэж байна.

				тайлагнаж дүгнэлт гаргуулан ажиллаж байна
Усны шинжилгээний үр дүнгээр гарсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах төлөвлөгөө гаргаж ажиллах	Усны чанарт гарсан өөрчлөлтийг хянаж, сайжруулах арга хэмжээг нэн даруй ава		Ажил үүргийн хуваарийн дагуу	Ус бэлтгэл хэсэгт сүүлийн үеийн шинэ технологи нэвтрүүлэн усны найрлагаанд байгаа магни, кальцийн карбонат агуулсан түр болон байнгын хатуулгыг арилгаж усыг 10мкг.эпв\дм3 болтол зөөлрүүлж байна. Усыг хийгүйжүүлэх төмрийн уртсэн деаэратори ажиллуулав

4.ХӨРСӨН БҮРХЭВЧ

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Гарах үр дүн	Хугацаа ба давтамж	Нийт зардал, мян.төг	Биелэлт
Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, доройтлыг хянаж байх хяналт мониторингийн ажлыг тасралтгүй явуулах	ДС-ын ашиглаж байгаа 3.24 га талбайн хөрсөн бүрхэвч үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтох нь багасах.	2022 онд	ОХШХ-т тооцсон	Сүлжээний шугам болон эзэмшлийн талбайн эвдэрсэн хөрсийг нөхөж сэргээсэн ажил хийгдсэн.
Нүүрсний агуулах болон станц орчмын нүүрсний хаягдлаар бохирдсон газрын хэмжээг цаашид	Хөрс, ургамлан нөмрөгийг эвдрэлд оруулж доройтуулахгүй байх нөхцөл бүрдэнэ.	2022 онд	Хог хаягдлын хэсэгт	Нүүрсийг нэгэл газар хадгалж оволж ашиглаж байна. Хөрсөнд нэвчсэн нүүрсийг цэвэрлэж байна. Мөн эзэмшлийн талбайн 10% тэнцэх хэмжээний газар болон өөр газар авч тербум мод хүрээнд аймгийн ойн

Зүлэгжүүлэлтэд зориулж ф50-н шугам 50м, ф32-н шугам 60 м-ийг худгаас татаж зүлэг услах	Орчны ногоон байгууламжийн арчилгаа сайжирч, ногоон байгууламжийг чадавхи дээшилнэ.	2022 онд	тооцсон	зуух засврын хэсгийн гагнуур сантехникийн мэргэжилтэй ажилчдуудад хийлгэж ашиглалтанд өгсөн. Тарьсан модуудыг зууны улиралд услах ажилууд тус2 хийгдсэн.
--	---	----------	---------	--

5. ОРЧИН СУУГЧДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ

Станцын нөлөөллийн бүсэд нэмж газар олголт хийлгэхгүй талаар арга хэмжээ авах			Тусгай сан үүсгэх хэрэгтэй	Байгууллагын хуваас хүсэлт гаргаж аймгийн Газарын албад хүргүүсэн.
Станцын салхин дор суурьшилтай айл өрхийн гишүүд, оршин суугчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх	Нийгмийн хариуцлагын үүргээ биелүүлэх	жилд 1 удаа		Дэмжилэг үзүүлсэн байна.
Станцын ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, ажиллагсдад үзүүлэх нөлөөллийг	жилд 1 удаа	800 000	Аймгийн нэгдсэн эмнэлэгт нийт ажилчдыг хамааруулсан байна.

байх	бууруулах			
	Нийт зардал		7, 900 000₮	Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

“Эрчимбаян Өлгий” ХК

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн